



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 09 сарын 28 өдөр

Дугаар АМ74

Улаанбаатар хот

Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газрын балансад бүртгэлтэй барилга байгууламжийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 106 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын А/934 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Налайх дүүргийн 2 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах 27,846,333.86 /хорин долоон сая найман зуун дөчин зургаан мянга гурван зуун гучин гурван төгрөг наян зургаан мөнгө/ төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан барилга байгууламжийг актлан, данс бүртгэлээсээ хасч, өмчийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний өөрчлөлт хийж ажиллахыг Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газар /Ж.Алтангэрэл/-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй хоёрдогч түүхий эдийн зориулалтаар худалдан борлуулахаар үнэлсэн 1,000,000 /нэг сая/ төгрөгийн хөрөнгийг борлуулан, орлогыг Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Нийслэлийн төрийн сангийн 100200051024 тоот дансанд төвлөрүүлж, акт болон бусад баримт бичгийн бүрдэлд хяналт тавьж ажиллахыг Захиргаа санхүүгийн хэлтэс /А.Мөнгөн/-т үүрэг болгосугай.


3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Рэнцэнбямбад даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

Нийслэлийн Өмчийн ашиглалт удирдлагын
газрын даргын 2020 оны 09. дугаар сарын
28....-ний өдрийн А/4.44 тушаалын хавсралт



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛЭЭС ХАСАХ БАРИЛГЫН ЖАГСААЛТ

төгрөгөөр

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Ашиглалтанд орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ
1	Ачлал Налайх Өрхийн эрүүл мэндийн төвийн барилга	18	2002	ш	1	25,746,333.86	1,787,939.85	23,958,394.01
2	Ачлал Налайх Өрхийн эрүүл мэндийн төвийн барилгын халаалтын зуух	15	2002	ш	1	2,100,000	2,100,000	-
Нийт					2	27,846,333.86	3,887,939.85	23,958,394.01